



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

# **2018**

 70592225, 70593208, 70592208,  
70592225

 [WWW.AUDIT.MN](http://WWW.AUDIT.MN)

 ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР

 [DUNDGOVI@AUDIT.GOV.MN](mailto:DUNDGOVI@AUDIT.GOV.MN)

## Гарчиг

Товчилсон үгийн тайлбар .....	3
НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	4
1.1 Бүтэц, зохион байгуулалт .....	4
1.3 Аудитын үр дүнгийн статистик үзүүлэлт .....	5
ХОЁР. АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	6
2.1 Санхүүгийн тайлангийн аудит .....	6
2.2 Гүйцэтгэлийн аудит .....	8
2.3 Нийцлийн аудит.....	12
2.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын хэрэгжилт .....	15
2.5 Орон нутгийн 2019 оны төсвийн төсөлд хүргүүлсэн санал .....	15
ГУРАВ. СУРГАЛТ .....	16
3.1 Мэргэжлийн тасралтгүй сургалт .....	16
3.2 Бүсийн сургалт .....	17
ДӨРӨВ. ДОТООД АЖИЛ .....	18
4.1 Санхүүгийн үйл ажиллагаа .....	18
4.2 Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх, олон нийтэд чиглэсэн арга хэмжээ .....	19
4.3 Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх .....	22
4.4 Архив, албан хэрэг хөтлөлт .....	22

## Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ХАК	Хувийн аудитын компани
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
НА	Нийцлийн аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан

## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018-12-05

Мандалговь

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.1 Бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын Ерөнхий аудитор 2018 онд “**Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх**” зорилтыг дэвшүүлсэн.

Дээрх зорилтын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, аудитын менежер, ахлах аудитор, аудитор нарын үр дүнгийн гэрээ байгуулж, үйлчилгээний ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллав.



Төрийн аудитын газар Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу санхүүгийн аудитын албанд 4, гүйцэтгэлийн аудитын албанд 2, нийцлийн аудитын албанд 2 хүний бүрэлдэхүүнтэй, 3 багийн зохион байгуулалтаар нийт 11 орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна. Нягтлан бодогч, дотоод ажил хариуцсан ажилтан, нярав-жолоочтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаа. Ажиллагсдын 10 нь нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, үүнээс 5 нь Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч байна.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар анх удаа “Таныг сонсьё” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, энэ үеэр 2017 оны ажлын үр дүнгээр хамт олноо манлайлсан ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Ж.Угтахбаяр болон аудитороор ажиллаж байсан С.Жалбаа нар Сангийн яамны “Жуух бичиг”-ээр, нярав-жолооч Ж.Мөнхбал “Онц тээвэрчин” цол тэмдгээр шагнагдсаныг гардуулж өглөө.

Тайлант онд Төрийн аудитын газар нэгдсэн удирдамжаар нийцлийн 2, гүйцэтгэлийн 4, өөрийн санаачилга болон аймгийн ИТХ-ын захиалгаар нийцлийн 3, гүйцэтгэлийн 3 аудит хийхээр төлөвлөснөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 92 хувь буюу 11 аудитыг бүрэн гүйцэтгээд байна.

НА

Нэгдсэн удирдамжаар 2, өөрийн санаачилга болон аймгийн ИТХ-ын захиалгаар 3 аудит гүйцэтгэхээр төлөвлөснийг бүрэн гүйцэтгэлээ.

ГА

Нэгдсэн удирдамжаар 4, өөрийн санаачилга болон аймгийн ИТХ-ын захиалгаар 3 аудит гүйцэтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийн 6 аудитыг бүрэн гүйцэтгэж, 1 аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг хэрэгжүүлж байна. Үүнээс 2 аудитыг судалгааны түвшинд гүйцэтгэсэн!


СТА

Санхүүгийн тайлангийн аудитад 209 байгууллага хамрагдаж, бүх шатны төсөв захирагч нарт аудитлагдсан тайлан, гэрчилгээг гардуулан өгөөд байна.


### 1.3 Аудитын үр дүнгийн статистик үзүүлэлт

Төрийн аудитын газар нь 2018 онд гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитаар нийт **19,454.5** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн нь өмнөх оноос 22 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт алдаа, зөрчил /тэр бум ₮/



хугацаа хэтрэлттэй зээлийн 53 хувийг барагдуулаад байгаа нь сайн үзүүлэлт юм.



Тайлант хугацаанд хохирлыг нөхөн төлүүлэх **521.1** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос **35.6** сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод, **225.2** сая төгрөгийг тухайн байгууллагын дансанд төвлөрүүлснээр хэрэгжилт 50 хувьтай байна. Үүнээс **7.9** сая төгрөгийн төлбөрийн актын барагдуулах хугацаа болоогүй бөгөөд **252.3** сая төгрөгийн төлбөрийн акт хэрэгжээгүй нь Сум хөгжүүлэх сангийн 2011 оноос хойш олгогдсон, огт төлөгдөхгүй байсан хугацаа хэтрэлттэй зээлийн авлагын барагдуулалт удаашралтай байгаатай холбоотой байна. Аймаг, сумдын Засаг дарга, Төрийн аудитын газраас шаардсаны дагуу нийт

Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар нийт **7,254.7** сая төгрөгийн 267 хугацаатай албан шаардлага өгснөөс **4,651.6** сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байгаа бөгөөд **2,408.1** сая төгрөгийн 204 албан шаардлагыг буюу **97** хувийг харилцагч байгууллага хугацаанд нь хэрэгжүүлж хариу ирүүлжээ.

Тайлант онд **123** заалт бүхий зөвлөмжийг харилцагч байгууллагад хүргүүлснээс **43** нь хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй бөгөөд **74** заалт нь хэрэгжиж 93 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад **1,468.2** сая төгрөгийн үр өгөөж бүртгэж, **9,613.1** сая төгрөгийн алдааг залрууллаа.

Байгууллага 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт **1,204.5** сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд нэг төгрөгт ногдох үр өгөөж **12.5** төгрөг байна.

## 2.1 Санхүүгийн тайлангийн аудит



Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 15.2.2 дахь заалт, 18.2 дахь хэсэгт заасны дагуу бүх шатны төсөв захирагч нарын болон ОНӨААТҮГ-уудын 2017 оны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажууллаа.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан **1**, сумдын нэгтгэсэн тайлан **15**, нийгмийн даатгалын нэгтгэсэн тайлан **1**, Засгийн газрын тусгай сангийн **4**, орон нутгийн тусгай зориулалтын сангийн **31**, төсвийн шууд захирагчийн **139**, ОНӨААТҮГ-ын **18**, нийт **209** байгууллагын санхүүгийн тайлан хамрагдав.




Санхүүгийн тайлангийн аудитад нийт 210 төсөв захирагчийн санхүүгийн тайлан хамрагдахаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан журмын дагуу шалгуур хангасан **13** байгууллагад итгэл үзүүлж, аудит хийлгүй өнжөөж, үйл ажиллагаа явуулаагүйгээс Хот тохижуулах газар ОНӨААТҮГ-т аудит хийгдээгүй. Аудитад хамрагдсан

байгууллагуудаас **67** төсвийн шууд захирагч, **31** орон нутгийн тусгай зориулалтын сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, **98** байгууллагад дүгнэлт гаргасан.

Үүнээс **89** байгууллагад “**Зөрчилгүй**”, 8 санхүүгийн тайланд “**Хязгаарлалттай**”, 1 байгууллагад “**Санал дүгнэлт өгөхөөс татгалзах**” санал дүгнэлт гаргалаа.

Хараат бус аудитын компанид 24 байгууллага хуваарилан гүйцэтгүүлсэн нь нийт дүгнэлт гаргах байгууллагын 24 хувийг эзэлж байгаа бөгөөд бүх байгууллагуудад “**Зөрчилгүй**” санал дүгнэлт гаргасан байна.

### Санал дүгнэлт




“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төв, Өндөршил сумын ЗДТГ, Аймгийн Номын

сан, Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төв, Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч, Баянжаргалан, Цагаандэлгэр, Гурвансайхан сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга нарт буюу 16 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж, 10 албан хаагчид “Сануулах”, 6 албан хаагчид “Цалин бууруулах” сахилгын шийтгэл ногдуулсан байна.

“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч нарыг ажлаас халах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг 100 хувь тооцсон.

### Алдаа, зөрчил




Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **11,926.0** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залруулж болох **9,159.3** сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. Тайлант онд **2,152.1** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр **496.1** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 50 заалт бүхий **73.5** сая төгрөгийн зөвлөмжийг шалгагдагч байгууллагад өглөө.

Мөн санхүүгийн тайлангийн аудитын явцад хууль тогтоомж зөрчсөнөөс гадна гэмт хэргийн шинжтэй байх магадлалтай нийт **43.6** сая төгрөгийн 4 асуудлыг Авлигатай тэмцэх газар болон аймгийн

Цагдаагийн газарт шилжүүлсэн.

2018 онд санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт **99.9** хувийн хэрэгжилттэй, тогтоосон төлбөрийн актын **49** хувь нь хэрэгжсэн байна. Төлбөрийн актын **93** хувийг Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлийн авлагыг барагдуулах акт эзэлж байгаа бөгөөд актыг



барагдуулах талаар сумдын Засаг дарга нартай зээлийн авлага барагдуулах хугацааг тохирон, уулзалтын тэмдэглэлээр баримтжуулсан. Үүний дагуу сумдын Засаг дарга, ажил хариуцсан мэргэжилтнүүд ажлын төлөвлөгөө гарган, нийт

хугацаа хэтрэлттэй зээлийн 53 хувийг төвлөрүүлсэн нааштай үр дүн гарч байгаа юм.

Тайлант онд өгсөн 50 заалт бүхий зөвлөмж 100 хувь хэрэгжсэн нь сумдад ажиллах үедээ өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт аудитаар илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийн тайланг ирүүлж хэвших талаар зөвлөж, цаашид хамтарч ажиллахад анхаарах асуудлуудыг ярилцан, ажил сайжруулах зөвлөмж өгч үүрэгжүүлсний үр дүн гарч байна.

*Аудитад зарцуулсан хүн/өдөр 1069, аудитын өртөг 103.5 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 402.3 сая төгрөг.*

## 2.2 Гүйцэтгэлийн аудит





ҮАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 2018 онд “Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудад аудит хийх”, “2018 он төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”, “Төрийн сангийн үйл ажиллагааны тогтолцоо, үр дүн” гэсэн сэдвээр 4 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөснөөс 2 аудитыг судалгааны түвшинд гүйцэтгэж, холбогдох судалгаа, зөрчлийн жагсаалтыг Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлэн, 2 аудитыг бүрэн гүйцэтгэж, Санхүүгийн аудитын газар болон шалгагдагч байгууллагуудад хүргүүллээ.

Аймгийн ИТХ-ын захиалга болон өөрийн санаачилгаар “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн”, “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн” сэдвүүдээр 3 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөснөөс 2 аудитыг бүрэн гүйцэтгэж, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн”-д хийж буй гүйцэтгэлийн аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг хэрэгжүүлж байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт **1,357.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залруулж болох **453.6** сая төгрөгийн алдааг залруулсан. Тайлант онд **770.7** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр **7.5** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, үр ашиг дээшлүүлэх, хууль тогтоомж хэрэгжүүлэх, дотоод хяналтыг сайжруулах талаар 12 заалт бүхий зөвлөмжийг тус тус өглөө.





2018 онд гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт 96 хувьтай, тогтоосон төлбөрийн актыг барагдуулах хугацаа болоогүй байна. Тайлант онд өгсөн 12 заалт бүхий зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.

Төрийн аудитын газрын 2018 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын дүнг дараах байдлаар харууллаа. Үүнд:



2.2.1 “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж аудитын нотлох баримтанд үндэслэн “**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүн муутай байна.**” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 63.7 хувь нь Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ байсан.

Аудитаар хийгдэх ажил, хүрэх үр дүн тодорхойгүй, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг бөөн дүнгээр баталсан, зарим худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсөвт өртгийг өөрчлөн тендер зарласан, тендерийн хавтаст хэргийн материалын бүрдэл дутуу, үнийн санал ирүүлэх тендерийн урилгыг хүргүүлсэн баримт байхгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Аудитаар нийт 270.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 144.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 125.8 сая төгрөгийн алдаа дутагдалд зөвлөмж өгч ажилласан.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 54, аудитын өртөг 3.0 сая төгрөг.



2.2.2 “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжаар гүйцэтгэсэн аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг хийж, холбогдох судалгааг ҮАГ-т хүргүүллээ.

Аудитаар барилгын засварын ажлыг барилгын хувийн хэрэгт хөтлөөгүй, гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгосон, зарим худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсөвт өртгийг өөрчлөн тендер зарласан, тендерийн хавтаст хэргийн материалын бүрдэл дутуу,

үнийн санал ирүүлэх тендерийн урилгыг хүргүүлсэн баримт байхгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Аудитын төгсгөлд өргөтгөсөн Удирдлагын зөвлөлийн хурал хийж, аудитын дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулсан.

*Аудитаар нийт 119.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж түүнийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.*

*Аудитад зарцуулсан хүн/өдөр 105, аудитын өртөг 5.0 сая төгрөг, бүртгэсэн аудитын үр өгөөж 30.8 сая төгрөг, тооцсон үр өгөөж 0.9 сая төгрөг.*

**2.2.3 “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудад аудит хийх”** сэдвээр ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжаар гүйцэтгэсэн аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг хийж, тус аудиттай холбоотой судалгааг заасан хугацаанд хүргүүлсэн.

Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын дуусаагүй орхигдсон барилгад мэргэжлийн шинжээч ажилласантай холбогдуулан хэмжилт хийх, фото зураг авч баримтжуулах, барилгын ажлын зураг төсөлтэй тулгалт хийх зэрэг ажлыг гүйцэтгэхэд хамтарч ажилласан.



**2.2.4. “Нийтлэг үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн**-д өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн аудит хийж, тайланг аймгийн Засаг дарга, ИТХ, Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн **“Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” хэлбэрээр бие даан үйл ажиллагаа явуулах боломжгүй байна.”** гэсэн дүгнэлт өгсөн.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын хууль эрх зүйн зөрчилтэй байдал, өөрийн орлогоор өөрийгөө санхүүжүүлдэггүй, дийлэнх үйл ажиллагаа аймгийн Засаг даргын Тамгын газарт чиглэсэн, хараат бусаар, бие даан үйл ажиллагаа явуулахгүй байгаа, өр, авлагыг зохистой удирдаагүй, санхүүгийн үзүүлэлтүүдийн харьцаа алдагдсан зэргээс шалтгаалан дээрх дүгнэлтийг өглөө.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, аймгийн ЗДТГ-ын харьяанд ажиллуулах саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн.

*Мөн хөрөнгийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогоос орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээгүй 5.1 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.*

*Аудитад зарцуулсан хүн/өдөр 140, аудитын өртөг 8.4 сая төгрөг, бүртгэсэн аудитын үр өгөөж 5.1 сая төгрөг.*

**2.2.5 “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын эргэн төлөлтийн байдал”** сэдэвт ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжаар гүйцэтгэсэн аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг гүйцэтгэсэн.

Тус аудиттай холбоотой ҮАГ-аас ирүүлсэн судалгааг заасан хугацаанд гүйцэтгэж хүргүүлсэн. Дундговь аймгийн хэмжээнд нийт 43 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан төслийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, фото зураг авч баримтжуулсан.

**2.2.6 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн”-д** хийж буй гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан, батлуулж гүйцэтгэлийн үе шатны ажлыг хэрэгжүүлж байна. Аудитаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой статистик мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулах, эмнэлгийн үйлчилгээнд ажиглалт хийх, 1500 орчим иргэдээс санал асуулга авч нэгтгэх зэрэг ажлууд хийгдэж байна.

Мөн аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сайнцагаан, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Говь-Угтаал сумдын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг хамруулж, холбогдох горим сорилыг хэрэгжүүлээд байна.



**2.2.7 “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д** гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, нотлох зүйлсэд үндэслэн **“Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, батлах шаардлагатай байна”** гэж дүгнэлээ.

Аудитаар Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.4, 16.5.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн. Үүнд:

- төсвийн хөрөнгөөр уралдаан тэмцээн зохион байгуулсан;
- ээлжийн амралтын нөхөн олговор, томилолтыг илүү тооцож олгосон;
- төрийн үйлчилгээний албан хаагчид үр чадварын нэмэгдэл олгоходоо журамд заасан шалгуурын дагуу ажлыг үнэлээгүй;
- хүнсний материалыг батлагдсан нормыг мөрдөлгүй хяналтгүй зарцуулсан;
- гэрээ байгуулсан боловч зарцуулалтыг дүгнэлгүй шатахуун зарцуулж, зардалд тайлагнасан зэрэг.

Үүнээс гадна Баянжаргалан сумын төсвийн байгууллагууд худалдан авсан нүүрсний үнийн хөнгөлөлтийг анхан шатны баримтгүйгээр төрийн бус байгууллагын дансанд шилжүүлсэн, Цагаандэлгэр сумын Цэцэрлэг нь ашиглалтгүй байгаа барилгыг цахилгаан халаалтаар халаан үр ашиггүй зардал гаргасан.

Санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитаар дээрх алдаа зөрчлүүд давтагдан гарч байгаа нь холбогдох байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнууд болон дотоод хяналтын ажилтнуудын ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалж байгаа юм.

*Аудитаар нийт 956.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 453.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 2.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 500.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.*

Мөн хуулийн хэрэгжилтийг сайжруулахаар аймгийн Засаг даргад 3 заалт, Орон нутгийн өмчийн газарт 1 заалт зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 54, аудитын өртөг 6.4 сая төгрөг, бүртгэсэн аудитын үр өгөөж 2.4 сая төгрөг.



2.2.8 “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, нотлох зүйлсэд үндэслэн “Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа ч тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.” гэсэн дүгнэлт өглөө.

Аудитаар сумдын төрийн сангийн нэгжүүдийн хяналт сул байгаагаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон, түрээсийн орлогын 20 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй, үнэт цаасны тооцоолол дутуу бодож орлого дутуу тайлагнасан, томилолтын хоног буруу тооцож илүү, дутуу олгосон, ажилтныг ажлаас чөлөөлөхдөө ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс амралтын мөнгө илүү олгосныг суутгаагүй зэрэг хууль тогтоомж зөрчин хийгдсэн зөрчилтэй гүйлгээнүүд нийтлэг илэрсэн.

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн Санхүү, төрийн сангийн хэлтэст 3 заалт бүхий зөвлөмж, Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн яаманд уламжлуулахаар 3 саналыг тус тус хүргүүллээ.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 110, аудитын өртөг 24.8 сая төгрөг.

## 2.3 Нийцлийн аудит



Тайлант хугацаанд ҮАГ-ын нэгдсэн удирдамж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу 2 нийцлийн аудит хийхээр төлөвлөн, аудитыг бүрэн гүйцэтгэж, аудит бүрийн төгсгөлд өргөтгөсөн Удирдлагын зөвлөлийн хурал хийж, аудитын дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан, аудитын тайланг тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан ҮАГ-т хүргүүллээ.

Мөн Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар 2, өөрийн санаачлагаар 1 нийцлийн аудит хийхээр төлөвлөснийг бүрэн гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудал авсан намуудын тус аймаг дахь мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нам эвсэл, нэр дэвшигч тус бүрээр дүгнэн, нэгтгэх ажлыг гүйцэтгэсэн.

Нийцлийн аудитаар нийт 6,171.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залруулж болох 0.3 сая төгрөгийн алдааг залруулсан. Тайлант онд 4,331.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 17.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, хууль тогтоомж хэрэгжүүлэх талаар 61 заалт бүхий зөвлөмжийг шалгагдагч байгууллагад өглөө.

2018 онд гүйцэтгэсэн нийцлийн аудитын дүнгийн талаар товч танилцуулбал дараах байдалтай байна. Үүнд:



**2.3.1 “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн 2017 оны зарцуулалт”** хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн **“ОНХС-гийн гүйцэтгэлд тавих хяналт, иргэдийн оролцоо хангалтгүй хэвээрээ байна.”**, **“СХС-ийн зээлийн зарцуулалтад хяналт тавиагүйгээс хугацаа хэтрэлттэй авлага өсчээ.”** гэсэн дүгнэлт өглөө.

ОНХС-ийн аудитаар сангийн хөрөнгийг зориулалтын бус зардалд зарцуулсан, иргэдийн саналаар дэмжигдээгүй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй ажлыг жагсаалтад оруулж санхүүжүүлсэн, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн, сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл, тайланд

тусгаагүй зэрэг зөрчил дахин илэрсэн.

ОНХС-ийн 2014-2017 онд зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг тухайн оны эх үүсвэртэй харьцуулахад 2014 онд 83.6 хувийг, 2015 онд 27.2 хувийг, 2016 онд 20.4 хувийг, 2017 онд 8.2 хувийг тус тус эзэлж байгаа нь жил ирэх тусам зөрчлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.



2017 оны ОНХС-гийн зарцуулалтад хийсэн аудитаар нийт 274.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 845.6 сая төгрөгөөр, эх үүсвэртэй нь харьцуулахад 12.2 хувиар буурсан боловч өмнө гарсан зөрчлүүд арилахгүй, их бага хэмжээгээр давтагдаж байна.

СХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдэлд алданги тооцоогүй, зээл олгох дээд хэмжээнээс хэтрүүлэн зээл олгосон, тэргүүлэх чиглэлд ороогүй төслийг шалгаруулсан, зээл авсан иргэдийн хувийн хэргийн бүрдлийг

журмын дагуу бүрэн хангаж, баримтжуулан хадгалаагүй, сангийн зарцуулалтад хяналт тавиагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

**ОНХС болон СХС-ийн аудитаар нийт 587.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 587.2 сая төгрөгийн 15 хугацаатай албан шаардлага, аймаг, сумдын Засаг дарга нар, ЗДТГ-ын дарга нарт 13 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.**

**Аудитад зарцуулсан хүн/цаг 1678, аудитын өртөг 7.2 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын үр өгөөж 29.0 сая төгрөг.**



**2.3.2 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.” гэсэн дүгнэлт өглөө.**

Аудитаар нийт 5,381.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 455.4 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгуулахаар 1,193.9 сая төгрөгийн хугацаатай албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад, 1,365.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах тухай зөвлөмжийг ТЕЗ-д хүргүүлээ.

Тус аудитын дүнг аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, 15 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, бүх төсвийн байгууллагуудын удирдлага, Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт танилцуулан, ярилцлага хийсэн нь дараагийн аудитаар зөрчил буурах сайн талтай юм.

*Аудитад зарцуулсан хүн/цаг 1578, аудитын өртөг 2.8 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын үр өгөөж 1.8 сая төгрөг.*



**2.3.3 “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт”-д аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Аймгийн хэмжээнд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.” гэсэн дүгнэлт өглөө.**

Аудитаар нийт 15.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 1.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 14.5 сая төгрөгийн хохирлыг барагдуулахаар хугацаатай төлбөрийн акт тогтоож, 3 албан тушаалтанд зөрчлийг арилгуулах, 2 албан тушаалтанд

сахилгын шийтгэл ногдуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллалаа.

Тус аудитаар 14.8 сая төгрөгийн 9 санхүүгийн үр өгөөж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, 16.2 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар бүрэн хүлээн зөвшөөрүүлээ.

Аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн Татварын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт 24 заалт бүхий зөвлөмж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

*Аудитад зарцуулсан хүн/өдөр 137, аудитын өртөг 5.0 сая төгрөг, хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөж 12.8 сая төгрөг.*



**2.3.4 “Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа”-д хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Сонгон шалгаруулалтгүйгээр удирдах болон төрийн албаны жинхэнэ албан хаагчийг томилсон зөрчил байсаар байна.” гэсэн дүгнэлт өглөө.**

Аудитаар нийт 180.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 180.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж, төрийн жинхэнэ албан хаагч болон удирдах ажилтны томилгоотой

холбоотой зөрчлийг арилгуулахаар 14 албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

*Аудитад зарцуулсан хүн/өдөр 90, аудитын өртөг 5.4 сая төгрөг, бүртгэсэн аудитын үр өгөөж 164.0 сая төгрөг.*



**2.3.5 “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт”-д нийцлийн аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг бууруулж, хамрагдах малын тоог багасгаж байгаа нь өвчлөл нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.” гэсэн дүгнэлт өглөө.**

Аудитаар мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх зардлыг бодитой хуваарилаагүй, вакцины орлого, зарлагыг хөтлөөгүй, мал эмнэлгийн эм, био бэлдмэлийн ашиглалт, зарцуулалт, хадгалалтад бүх шатны хяналт тавиагүй, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Аудитаар нийт 6.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2.6 сая төгрөгийн хохирлыг барагдуулахаар хугацаатай 5 төлбөрийн акт тогтоож, 3.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

*Аудитад зарцуулсан хүн/цаг 1062, аудитын өртөг 5.1 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын үр өгөөж 1.8 сая төгрөг.*

## 2.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар 43.6 сая төгрөгийн 4 асуудлыг Цагдаагийн газарт шилжүүлсэн. Үүнээс Цагдаагийн газарт шилжүүлсэн 3 асуудалд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлийн 1.2 дахь хэсгийг удирдлага болгон хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан хариуг ирүүлээд байна.

Харин Гурвансайхан сумын Сум хөгжүүлэх сантай холбоотой 33.0 сая төгрөгийн асуудлыг Авлигатай тэмцэх газар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

“Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт”-д нийцлийн аудит хийх явцад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ХААГ-ын малын эм бэлдмэл, вакцины агуулахад хяналтын тооллого хийхэд шүлхий болон хонины цэцэг өвчний вакцин зөрүүтэй гарсан. Аудитын явцад хонины цэцэг өвчний вакцинд нарийвчилсан тооцоо хийж, анхан баримтаас хөөн шалгахад вакцин дутсан тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон бөгөөд шүлхий өвчний вакцин 590 шил /118,000 тун/ байхаас 609 шил /121,800 тун/ буюу 19 шил /3800 тун/ бүртгэлээс илүү байсан зөрчлийн хувьд саналын зөрүүтэйгээс аудитын хугацаанд шалгах боломжгүй болсон. Иймд энэ асуудлыг Цагдаагийн газарт шилжүүлсэн бөгөөд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байна. /Хавсралт №1-т хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын хэрэгжилтийг судалгааг орууллаа. /

## 2.5 Орон нутгийн 2019 оны төсвийн төсөлд хүргүүлсэн санал

Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4 дэх заалтад заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг даргаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн аймгийн 2019 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 57.8 сая төгрөг, орлого нэмэгдүүлэх боломжтой 200.2 сая төгрөгийн саналыг ИТХ-д оруулан, хэлэлцүүлсэн. Мөн төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар дараах саналуудыг бэлтгэж, ИТХ-д хүргүүлээ. Үүнд:

- ✚ Сургалтын үр дүнг бодитой тооцож, ирээдүйд бий болох үр өгөөжийг бий болгоход төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах;
- ✚ 2019 оноос хэрэгжих Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу буруутай албан тушаалтнаар төлүүлэх 159.5 сая төгрөгийг барагдуулах ажлыг зохион байгуулж, 2019 оны төсвийн зардлын эх үүсвэр болгох;
- ✚ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтад 421.8 сая төгрөгийн 10 ажил зөрчилтэй байгаа тул эдгээр ажлыг жагсаалтаас хасаж, Төсвийн тухай хууль болон ОНХС-ийн заавар журмыг мөрдөж ажиллах;
- ✚ Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэн, хөрөнгө худалдаж авахаар төлөвлөхдөө өмнөх хөрөнгийн ашиглалтыг судлаж шийдвэрлэх, ашиглалтын хугацаанаас өмнө ашиглах боломжгүй болсон тохиолдолд шалтгааныг тогтоох, шаардлагатай бол холбогдох хүмүүст хариуцлага тооцож байх.



## Гурав. Сургалт

### 3.1 Мэргэжлийн тасралтгүй сургалт

Мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлөвлөгөө гаргаж, дотоод болон гадагшаа чиглэсэн сургалтуудыг тогтмол зохион байгууллаа.



Аудитын менежер Х.Наранцацрал БНХАУ-ын Наньжин хотод зохион байгуулагдсан “Залилангийн эрсдэл, материаллаг байдлын түвшинг үнэлэх”, “Чанарын хяналт”, “Бэлчээрийн аудит”, “Их хэмжээний өгөгдөлтэй ажиллах” сэдвээр сургалтад хамрагдаж, заагдсан хичээлээр сургалт зохион байгуулж, танилцуулга хийсэн.

Сангийн яамнаас зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны аудит” сэдэвт сургалтанд ахлах аудитор Ч.Бэрхсайхан, Д.Ихбаяр нар хамрагдсан.

Үндэсний аудитын газраас зохион байгуулсан шинэ ажилтны сургалтанд аудитор Ж.Угтахбаяр, Р.Хаш-Эрдэнэ, аудитын менежерүүдийн сургалтад Х.Наранцацрал, “Чадамжийн хүрээний баримт бичиг боловсруулах” онилсон бүлгийн сургалт, ярилцлагад аудитор Д.Должинсүрэн, Т.Оюун-Эрдэнэ нар хамрагдаж, заагдсан сэдвээр дотоод сургалт зохион байгууллаа. Мөн Аудитын менежер Х.Наранцацрал Азийн хөгжлийн банкны мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагад оролцож, орон нутагт тулгарч буй хүндрэлтэй асуудал, ажлын ачаалал, СТАУС программын ашиглалттай холбоотой асуудлаар санал солилцсон.





“Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга бат” сэдэвт зөвлөгөөнд тэргүүлэх аудитор П.Төвсанаа төрийн албан хаагчдад хандан илтгэл тавьж, удирдах ажилтнуудын сургалтад тэргүүлэх аудитор П.Төвсанаа хөгжлийн асуудлаар, аудитын менежер Х.Наранцацрал “Төсвийн захирагч, санхүүгийн ажилтнуудын манлайлал, ажлын хариуцлага” сэдвээр сургалт зохион байгууллаа.



Мөн Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын төрийн албан хаагчдад тэргүүлэх аудитор П.Төвсанаа “Ёс зүй ёс суртахууны асуудал”, “Хөгжлийн асуудал” сэдвүүдээр илтгэл тавьж, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг сурталчиллаа.



Төрийн аудитын газраас аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Дундговь дахь салбартай хамтран эд хариуцагчийн судалгаа хийж, сургалт зохион байгуулахаар төлөвлөж, сургалтад хамрагдах эд хариуцагч нарын судалгааг нэгтгэж, сургалтын материалыг бэлтгэж байна.

Тус сургалтыг 2018 оны төгсгөл эсвэл 2019 оны эхээр хийхээр төлөвлөн ажиллаж байна.



Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад ахлах аудитор Ч.Бэрхсайхан, Д.Ихбаяр, аудитор Ж.Угтахбаяр, Р.Хаш-Эрдэнэ, Д.Должинсүрэн, нягтлан бодогч, дотоод ажил хариуцсан ажилтан Ч.Оюунтүлхүүр нар хамрагдаж, аудитор Д.Должинсүрэн Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авах болзол ханган, гэрчилгээг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч С.Бүрэнбатаас гардан авсан. Аудитор Ж.Угтахбаяр 5 хөнгөлөлт, ахлах аудитор

Д.Ихбаяр 3 хөнгөлөлт авч мэргэшсэн нягтлан болох шатыг нэгээр ахиулж ажиллаа. Бусад ажилтнуудын шалгалтын дүн хараахан гараагүй байна.

### 3.2 Бүсийн сургалт

Төрийн аудитын байгууллагын мэргэшлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийн хүрээнд бүсийн сургалтыг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 17-ны өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулсан.



Сургалтад Өмнөговь, Төв, Дундговь аймгийн нийт 30 аудитор оролцож, Үндэсний аудитын газрын Стратеги удирдлагын газрын дарга Д.Энхболд, ахлах шинжээч Б.Өлзий болон Тамгын газрын хүний нөөцийн мэргэжилтэн Г.Өлзидэлгэр, сургалт хариуцсан ажилтан М.Өлзиймягмар, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал,

Нийслэл дэхь Төрийн аудитын газрын аудитор У.Оюунхүү нар төрийн аудитын байгууллагын албан хаагчдад сургалтын хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай мэдээллийг өгч, мэдээлэл солилцов.

Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийх шинэ журам, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүй, аргачлалын өөрчлөлт, шинэчлэлийн талаар сургалт хийж, сэдэв тус бүрээр дадлага ажил зохион байгуулж, дүнг нэгтгэн ярилцаж, Төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын оролцооны стратегийн бодлогын баримт бичиг боловсруулахад санал авч, хэлэлцүүлэг явуулсан нь сургалтын онцлог байсан.



Мөн төрийн аудитын байгууллагад 5, 10 дахь жилдээ ажиллаж буй 7 аудитор /Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Наранцацрал /90%, ахлах аудитор Ч.Бэрхсайхан /90%, Т.Батсайхан /92.5%, аудитор Т.Оюун-Эрдэнэ /92.5%, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг, Л.Жаргалсайхан, аудитор Ж.Бямбацогт/ мэргэшлийн түвшин тогтоох шалгалтад амжилттай хамрагдаж, батламж гардан авлаа.

Үндэсний аудитын газрын Тамгын газраас Төв, Өмнөговь, Дундговь аймгуудын төрийн аудитын байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, чиглэлийг газар дээр нь өгч ажилласан нь ихээхэн үр дүнтэй ажил болсон.



## Дөрөв. Дотоод ажил

### 4.1 Санхүүгийн үйл ажиллагаа



2017 оны санхүүгийн тайланг стандартын дагуу үнэн зөв гаргаж хуулийн хугацаанд “Улаанбаатар аудит корпораци” ХХК –аар аудит хийлгэж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

Санхүүгийн тайланг улирал, хагас жилээр хуулийн хугацаанд гаргаж, төсвийн зарцуулалтын тайлан мэдээг сар бүр гаргаж ҮАГ-т хүргүүлсэн.

Төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын 2019 оны төсвийн төслийг боловсруулан баталгаажуулж, ҮАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.



2018 оны 11 дүгээр сарын байдлаар 194.4 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, 185.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2018 оны 05 сард ҮАГ-т хүргүүлсэн төсвийн зохицуулалт хийгдэж, өр төлбөртэй байсан байгууллагуудтай тооцоо нийлж, 11 сард тус бүрийн дансанд шилжүүлсэн. Өр төлбөрийн тодруулга тайланд өссөн дүнгээр бусад зардлын өр төлбөр 160.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 203.9 мянган төгрөгөөр тайлагнасан.

Батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн гүйлгээг хийж төсвийг, зориулалтын дагуу зарцуулж, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэст сар, улирал бүр тайлан гаргаж баталгаажуулан өгч, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэн ажиллаж байна.



Аймаг	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Баян-Өлгий	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянзавхан	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Баянхонгор	✓	✓	✓	✓	✓	✓	✓

Мэдээллийн ил тод байдлыг хангаж төсвийн гүйцэтгэлийн мэдээг ханын самбарт мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад сар бүр цаг хугацаанд нь байршуулж ажилласан.

## 4.2 Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх, олон нийтэд чиглэсэн арга хэмжээ

2018 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, мэдээ, үйл ажиллагаа, акт, албан шаардлагын талаар нийт 42 мэдээллийг ҮАГ-ын [audit.mn](http://audit.mn) вэб хуудас болон байгууллагын facebook хуудсанд байршуулсан байна.

Мөн хэвлэмэлээр болон хувилж өгсөн 27 тайлан, Дундговийн амьдрал сонинд нийтлүүлсэн хэвлэлийн мэдээ, нийтлэл 57 байна. Бусад байгууллагад мэдээлэл, сурталчилгаа давхардсан тоогоор 30 удаа хийж, радио, телевизийн мэдээ, нэвтрүүлэгт 2 удаа оролцжээ.



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас төрийн аудитын байгууллагын зорилго, чиг үүргийг иргэдэд үнэн зөвөөр хүргэж ойлгуулах, тэдний санал бодлыг сонсох зорилгоор “Таныг сонсье” нээлттэй хаалганы өдөрлөгийг анх удаа санаачлан зохион байгууллаа. Өдөрлөгийг Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумдын иргэд, төрийн албан хаагчид буюу 1000-аад иргэдийг хамруулан, нийт 4 удаа зохион байгууллаа.



Өдөрлөгийн хүрээнд 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, 2018 онд хийх аудитыг танилцуулж, 2019 онд хийх аудитын сэдвийн санал авах, аудитын байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, Шилэн дансны тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилттэй холбоотой асуудлуудаар санал асуулга авч дүнг нэгтгэж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган ажиллахаар шийдвэрлэсэн юм.

Өдөрлөгийн үеэр төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл авч, 10 гаруй иргэн асуулт асуун, санал шүүмжлэл хэлж төрийн аудитын байгууллагын тухай урьд өмнө нь мэдээлэл муутай байснаа илэрхийлж, анх удаа иргэдийн дунд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж буйд талархалтай хандан, цаашид төрийн бүх байгууллагууд иргэдээ сонсож, тайлангаа танилцуулан тэднээс үнэлгээ авч, ажлаа дүгнэж байх саналыг гаргаж байлаа.



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын танилцуулга, 2017 оны үйл ажиллагааны үр дүн, 2018 оны төлөвлөгөөг Дундговийн амьдрал сонинд тусгай дугаар болгон нийтлүүлж, 1000 ширхэг сонинг нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр тараалаа.

Мөн төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэсэн аудитуудын дүнг тогтмол нийтлүүлж байхаар Дундговийн амьдрал сонинтой гэрээ байгуулан ажиллаж байна.

Байгууллагын цахим хуудсанд хандах хандалтын тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор facebook хуудсаар дамжуулан гүйцэтгэсэн аудитын тайлан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол байршуулж байна.

2018 онд гүйцэтгэсэн нийцлийн аудитын тайлан

№	Аудитын нэр	Аудитын код	Тайлан үзэх
1	Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүн	/YAГ-НАГ-2018-02-НА/	Тайлан үзэх
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	/YAГ-НАГ-2018-01-НА/	Тайлан үзэх
3	Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт байдал	/ДУА-2018-01-НА/	Тайлан үзэх
4	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт	/ДУА-2018-03-НА/	Тайлан үзэх
5	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт	/ДУА-2018-02-НА/	Тайлан үзэх

2018 онд гүйцэтгэсэн санхүүгийн аудитын үед тогтоосон төлбөрийн акт, зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн албан шаардлага, сүүлийн 3 жилийн аудитын тайланг хүснэгтэн хэлбэрээр audit.mn цахим хуудсанд байршуулсан нь байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан бас нэгэн ажил байлаа.

№	Аудитын нэр	Алтын дугаар	Зөрчлийн дүн	Тогтоосон уугацаа	Түгээх
1	Эрдэнэдалай сум Экинэлэг	01/03	131,316	1/30/2018	Үзэх
2	Эрдэнэдалай ЭДИТ	01/05	1,354,706	2/9/2018	Үзэх
3	Эрдэнэдалай Соёлын төв	01/06	68,800	2/9/2018	Үзэх
4	Угсын бүртгэлийн хэлтэс	01/08	69,000	2/6/2018	Үзэх
5	Өндөршил Цэцэрлэг	01/18	307,351	2/22/2018	Үзэх
6	Өндөршил Соёл	01/21	20,000	2/22/2018	Үзэх
7	Эрдэнэдалай Сургууль	01/22	386,000	2/22/2018	Үзэх
8	Өндөршил ЭДИТ	01/26	93,000	2/23/2018	Үзэх
9	Улаанбаатар аялалын үйлчилгээний үйлдвэр	01/29	406,631	2/23/2018	Үзэх
10	Сайнцагаан 7-р цэцэрлэг	01/31	270,000	2/23/2018	Үзэх
11	Молын сан	01/39	270,000	2/23/2018	Үзэх
12	4-р сургууль	01/40	270,000	2/23/2018	Үзэх
13	Сайнцагаан 1-р цэцэрлэг	01/46	1,237,608	3/9/2018	Үзэх
14	Баянжаргалан СХС	01/10	42,723,841	2/15/2018	Үзэх
15	Өндөршил СХС	01/11	55,523,137	2/19/2018	Үзэх
16	Даран СХС	01/15	81,749,862	2/14/2018	Үзэх



Төрийн аудитын газрын ажилтнуудын гэр бүлийнхнийг хүлээн авч, төрийн аудитын байгууллага, ажилтнууд болон үйл ажиллагааны талаар танилцуулах нээлттэй өдөрлөг зохион байгуулсан нь ажилчдад ажиллах урам зориг, эрч хүч өгсөн ажил болсон.



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн бүх шатны захирагч нар, санхүү бүртгэлийн ажилтнуудын өдөр тутмын ажилд хэрэглэгдэж байдаг нэн чухал шаардлагатай Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, салбарын сайдын тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, бусад заавар журмыг эмхэтгэсэн. Аудитаар илэрч байгаа зөрчил дутагдлын 60-70 хувь нь санхүү бүртгэлийн ажилтны хууль, эрх зүйн мэдлэг, ажлын дадлага туршлага, чадвартай холбоотой, 30-40 хувь нь ажилтнуудын ажлын хариуцлага, сахилга бат, ажилд хандах хандлага, дотоод хяналт шалгалт, санхүүгийн удирдлагатай холбоотой гарсан байна. Иймд төсвийн сахилга батыг сайжруулах, орлого нэмэгдүүлж, зардлыг бууруулах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, арвилан хэмнэлтийн горимд ажиллаж сурах,

санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, аливаа алдаа дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход тус дэмжлэг үзүүлэх зорилгоор тус номыг бүтээв.

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өргөтгөсөн ээлжит VII хуралдаанд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа төсөв захирагч нарын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл хийсэн нь аудитаар илэрсэн зөрчлийг арилгах тайлагналын дараах үе шатны ажлыг үр дүнтэй болгох нэг ажил байв.



Аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, 15 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нар, аймгийн төв болон сумдын төсвийн байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарын нийт 200-гаад албан хаагчид “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитын дүнг танилцуулсан нь маш үр дүнтэй ажил боллоо.

Энэ үеэр Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудит, “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, аймгийн ерөнхий санхүүч шилэн дансны цахим хуудасны аль цэст ямар мэдээлэл оруулах талаар сургалт зохион байгууллаа.

Мөн аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг

хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсөв захирагч, нягтлан бодогч нарт үүрэг болгож, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг давтан гаргавал хариуцлага тооцох талаар анхааруулсан нь дараагийн аудитаар зөрчил багасах ач холбогдолтой байлаа.

### 4.3 Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх



Тэргүүлэх аудиторын ХАСХОМ баталгааны хуудсыг УАГ-ын Тамгын газарт хүргүүлж, ажилтнуудын ХАСХОМ-ийг нууцын ажилтан хүлээн авч, баталгааны хуудсыг хянаж, аудит бүрт ашиг сонирхлын зөрчилгүй талаарх мэдэгдлийг аудиторуудаар гаргуулан баталгаажуулж байна.

Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтан, нууц мэдээлэлтэй танилцах эрх бүхий албан хаагчдын мэдээллийг аймаг дахь Тагнуулын хэлтэст хүргүүлж, аюулгүй байдлын шалгалтад хамруулсан. Тэргүүлэх аудитор П.Төвсанаа, аудитын менежер Х.Наранцацрал, ахлах аудитор Д.Ихбаяр нарыг нууц мэдээлэлтэй танилцах эрх бүхий албан хаагчийн жагсаалтад оруулж, төрийн болон албаны нууц хамгаалах чиг үүргийг аудитор Б.Гантуяад хариуцуулсан.

Нууц хамгаалах чиг үүрэг бүхий албан хаагчид хуулийн дагуу тусгай өрөө гаргаж, өрөөг тохижуулан өгснөөр Тагнуулын хэлтэс болон УАГ-ын Тамгын газраас хийсэн шалгалтаар сайн үнэлгээ авлаа.

### 4.4 Архив, албан хэрэг хөтлөлт

Төрийн аудитын газарт 2018 онд нийт 475 албан бичиг ирж, 424 албан бичгийг харилцагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

Байгууллагуудад хүргүүлсэн 56 албан бичгээс хариу ирээгүй 12 албан бичиг байна.

Аудитын үйл ажиллагаатай холбоотой 209 албан шаардлага, 65 төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд архивын стандартын дагуу хэвлэжээ.

#### 2018 оны байгууллагын албан хэрэг хөтлөлтийн мэдээ

Албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хэвлэн, бүртгэлд бүртгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд цаасаар болон цахимаар хүргүүлсэн албан бичгүүд

Хүлээн авч, бүртгэлийн дэвтэрт бүртгэн, цохолт хийлгэн холбогдох хүмүүст өгсөн

Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын 209 албан шаардлага, 65 төлбөрийн акт

Байгууллагуудад 424 албан бичиг, 99 аудитын гэрчилгээ

Тэргүүлэх аудиторын А дугаар тушаал 25, Б тушаал 6

Хамт олны олон Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, аудитын дүнгийн хурлын тэмдэглэл 8

УАГ-аас ирсэн 89, бусад газраас ирсэн 475 албан бичиг, хариутай 56 албан бичиг

Тайлант хугацаанд Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Хүрэлбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч С.Бүрэнбат, Дотоод аудитын албаны дарга Д.Ганбилэг, Стратегийн удирдлагын газрын дарга Д.Энхболд нар Дундговь аймагт ажиллаж, төрийн аудитын байгууллагын дотоод үйл ажиллагаатай танилцан, цаашид хийх ажлын талаар зөвлөгөө, зөвлөмж, чиглэл өгч, бидний ажилд байгаа ололтыг улам баталгаажуулан, дутагдлыг засах, ажлаа эрчимжүүлэн сайжруулах талаар ажилтнуудад урам хайрлан, ажиллах урам зориг нэмсэн жил байлаа.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР...../П.ТӨВСАНАА/

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР...../Х.НАРАНЦАЦРАЛ/

## ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛСЭН АСУУДЛЫН ХЭРЭГЖИЛТ

дд	Байгууллагын нэр	Төсөв захирагчийн нэр	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Зөрчлийг гаргасан албан тушаалтан	Хууль хяналтын ямар байгууллагад шилжүүлсэн	Шилжүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Шийдвэрлэсэн байдал	Явц
1	Гурвансайхан сумын Сум хөгжүүлэх сан	Сумын Засаг дарга Л.Өлзийбат	2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Засаг даргын үүрэг гүйцэтгэгч С.Өлзийбуян /одоо Засаг даргын орлогчийн албан тушаалд ажиллаж байгаа/ Засаг даргын А/110 дугаар захирамжаар М.Эрдэнэсүрэнд 15,000,000.00 /арван таван сая/, Ш.Хадбаатарт /18,000,000.00 /арван найман сая/ төгрөгийг тус тус олгосон байна. авсан зээлүүдээр хаасан нь баримтаар нотлогдож байгаа юм. Мөн М.Эрдэнэсүрэн нь Гурвансайхан сумын ЗДТГ-ын дарга Б.Туяагийн төрсөн ээж, Ш.Хадбаатар нь Гурвансайхан сумын Санхүүгийн албаны дарга Ү.Алимаагийн нөхөр тул ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй гэж үзэж байна.	33,000.0	Засаг даргын орлогч С.Өлзийбуян	Авлигатай тэмцэх газарт орон нутаг дахь хяналтын дэд зөвлөлөөр дамжуулан шилжүүлсэн боловч хүлээн аваагүй гэсэн тайлбар өгсөн. Иймд аймаг дахь Цагдаагийн газарт шилжүүлсэн.	Авлигатай тэмцэх газарт 2018.02.06-ны №47 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дундговь аймаг дахь Цагдаагийн газарт 2018.09.11-ний өдрийн 331 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.	Шийдвэрлэгдээгүй байгаа.	2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн талаар мэдэгдсэн. Одоо Авлигатай тэмцэх газарт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа.



дд	Байгууллагын нэр	Төсөв захирагчийн нэр	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Зөрчлийг гаргасан албан тушаалтан	Хууль хяналтын ямар байгууллагад шилжүүлсэн	Шилжүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Шийдвэрлэсэн байдал	Явц
2	Хулд сумын Мал хамгаалах сан	Хулд сумын Засаг дарга Ч.Зоригтбаатар	2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 4,304,800.00 /дөрвөн сая гурван зуун дөрвөн мянга найман зуун/ төгрөгийн өвс тэжээлийн авлага тусгагдсан ба жилийн эцсийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлэх явцад “өвсний үнийг бэлнээр төлсөн”, “өвс худалдан аваагүй” гэх мэтээр тайлбар бичиж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Авлага барагдуулах иргэд Мал хамгаалах сангаас өвс худалдан аваагүй, эсвэл худалдан аваад хариуцсан албан хаагчид төлбөрийг шилжүүлсэн гэх зэрэг тайлбарыг хэлж байгаа нь Мал үржлийн тасгийн дарга тус мөнгийг хувьдаа завшсан байх магадлалтай гэж үзсэн.	4,304.8	Мал үржлийн тасгийн дарга Б.Батмөнх	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	2018.02.23-ны өдрийн №104 дугаар албан бичиг	Цагдаагийн газрын 2018.07.04-ний өдрийн 40/1368 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг удирдлага болгон Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн боловч хуулийн үйлчлэлд хамаарахгүй гэж үзээд Цагдаагийн газарт буцаасан. Цагдаагийн газарт 182200094 дугаартай хэрэг нээн шалгаж хаасан.

дд	Байгууллагын нэр	Төсөв захирагчийн нэр	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Зөрчлийг гаргасан албан тушаалтан	Хууль хяналтын ямар байгууллагад шилжүүлсэн	Шилжүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Шийдвэрлэсэн байдал	Явц
3	Өлзийт сумын Хүүхдийн цэцэрлэг	Ц.Наранбаатар	<p>Албан хаагчид олгох жирэмсэн амаржсаны тэтгэмжийг төлбөрийн хүсэлтэд бичигдсэн дансанд шилжүүлэлгүй нийт 1,507,396.00 /нэг сая таван зуун долоон мянга гурван зуун ерэн зургаан/ төгрөгийг нярвын харилцах дансанд шилжүүлэн авсан. Нярав ажилтанд олгох жирэмсэн амаржсаны тэтгэмжийг бэлнээр гарган авсан бөгөөд тухайн хүнд хугацаа хожимдуулан олгосон.</p> <p>Ашмаг ХХК-аас өгсөн хандивын 1,000,000.00 /нэг сая/ төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд шилжүүлэлгүйгээр нярвын бэлэн мөнгөний дансанд хүлээн авч, бэлнээр гарган шийдвэргүйгээр зарцуулсан. Тус гүйлгээг санхүүгийн тайланд тусгаагүй, зарцуулалтад хуурамч баримт бүрдүүлсэн. Ашмаг ХХК-аас гадна Эх орд майнинг ХХК-тай гэрээ байгуулан ажилладаг гэсэн тайлбар өгсөн бөгөөд Эх орд майнинг ХХК-аас өгсөн хандивыг тайланд тусгаагүй байж болзошгүй гэж үзсэн.</p>	2,507.4	Цэцэрлэгийн дарга асан Ч.Буянжаргал	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	2018.03.05-ны өдрийн №134 дугаар албан бичиг	Цагдаагийн газрын 2018.03.20-ны өдрийн 40/546 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн.	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан.

дд	Байгууллагын нэр	Төсөв захирагчийн нэр	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Зөрчлийг гаргасан албан тушаалтан	Хууль хяналтын ямар байгууллагад шилжүүлсэн	Шилжүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Шийдвэрлэсэн байдал	Явц
4	Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	Захирал Б.Наранцэцэг	Тус газрын санхүүгийн тайланд тусгагдсан 7,239.7 мянган төгрөгийн авлагаас 3,762.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, харилцагчид “тус авлагыг төлсөн”, “тооцоо байхгүй” гэх шалтгаанаар хүлээн зөвшөөрдөггүй байна. Аудитын явцад 2 хувь хүнийг сонгон, тухайн байгууллагад өртэй эсэх талаар ярилцлага хийхэд “тийм тооцоо байхгүй” гэсэн тайлбар өгсөн. Иймд тухайн авлагыг барагдуулах эзэн холбогдогч тодорхойгүй байгаа тул байцаалт явуулах шаардлагатай гэж үзсэн.	3,762.5	Нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Даваа	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	2018.03.26-ны өдрийн №159 дугаар албан бичиг	Цагдаагийн газрын 2018.07.04-ны өдрийн 40/1368 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн.	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан.

дд	Байгууллагын нэр	Төсөв захирагчийн нэр	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Зөрчлийг гаргасан албан тушаалтан	Хууль хяналтын ямар байгууллагад шилжүүлсэн	Шилжүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Шийдвэрлэсэн байдал	Явц
5	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Б.Мөнхжаргал	"Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт"-д нийцлийн аудит хийх явцад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ХААГ-ын малын эм бэлдмэл, вакцины агуулахад хяналтын тооллого хийсэн. Тооллогоор нярвын тайланд үлдэгдэлгүй байсан хонины цэцэг өвчний вакцин 73 шил /бог малаар тооцоход 14,600 тун/, шүлхий өвчний вакцин 590 шил /118,000 тун/ байхаас 609 шил /121,800 тун/ буюу 19 шил /3800 тун/ бүртгэлээс илүү байсан. Хонины цэцэг өвчний вакциныг анхан шатны баримтуудаас хөөн шалгахад 2016 онд 118 шил буюу 11.8 мянган тун вакцин дутагдаж, 2017 онд 41.0 мянган тун буюу 205 шил вакцин дутагдсан. Дутагдсан вакциныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон бөгөөд шүлхий өвчний вакцин 590 шил /118,000 тун/ байхаас 609 шил /121,800 тун/ буюу 19 шил /3800 тун/ бүртгэлээс илүү байсан зөрчлийн хувьд саналын зөрүүтэйгээс аудитын хугацаанд шалгах боломжгүй болсон.	-	Мал эмнэлгийн албаны дарга М.Хүүбаян	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	2018.08.09-ний 325 дугаар албан бичиг	Шийдвэрлэгдээгүй байгаа.	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байгаа.
<b>Дүн</b>				<b>43,574.7</b>					

